ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АВЛИГЫН ЭСРЭГ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд **сурталчлах, соён гэгээрүүлэх** үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.	Байгууллагын албан ёсны веб хуудас болон фэйсбүүк цахим хуудсанд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 2 видео шторк /Авилгын эсрэг нэгдээ нэртэй 30 секундын шторк, Үгүй гэж хэлээд өөрчилье 3 минут 34 секундын шторк/, Авилгын эсрэг нэгдээ сэдэвт 5 зурагт хуудас, сурталчилгааны материалыг байршуулан нийт 5912 хандалт авсан. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын тухай ойлголт мэдээлэл өгөх гарын авлага бэлтгэн төвийн веб болон цахим хуудсанд байршуулж, олон нийтэд сурталчилсан. Тус гарын авлагыг орон нутгийн Зоонозын өвчин судлалын 14 төвүүдийг хэвлэх болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилахын зөвлөсөн.
		1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	Тус төв нь үйлчлүүлэгчгүй, оргүй эмнэлэг учир байгууллагын онцлогт тохируулан нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын онцлогт тохируулан 2 удаагийн бүлгийн хэлэлцүүлэг өрнүүллээ. Хэлэлцүүлэг хүний нөөцийн болон санхүүгийн ил тод байдлыг хангах, тендэрийн үйл ажиллагааг ил тод, шударга, авлига ашиг сонирхлын зөрчилгүй байх сэдвийн хүрээнд өрнөсөн.
		1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Тус төвийн нийт ажилтан, албан хаагчдад Авлигын эсрэг үйл ажиллагааг цахимаар дамжуулан сурталчилж, мэдээллийг байгууллагын ажилтны цахим группд тухай бүр байршуулсан.

				Мөн мэдээллийн самбарт авлигын эсрэг аяны зурагт хуудас, боловсруулсан гарын авлагыг байршуулан, мэдээлэл хүргэсэн.
		1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.	Тус төвийн эмч, мэргэжилтнүүдийн төлөөллийг оролцуулан “Авлигын эсрэг нэгдэе-Үгүй гэж хэлээд өөрчилье” сэдэвт 1 минут 30 секундын контент хийж, төвийн веб болон цахим хуудсанд байршуулан, авлигын эрсдэлээс ангид байх, урьдчилан сэргийлэх сурталчилгааг олон нийтэд түгээсэн. Нийт хандалт 3614 байна. Холбоос: https://www.facebook.com/nczd.gov/videos/862832731892069/
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх;	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	2023 онд тус төвийн Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга болон Санхүү хангамж, үйлчилгээний албаны дарга, Нөөцийн агуулахын Чанарын менежер-эм зүйч нар шинээр албан тушаалд томилогдсон. Албан тушаалд томилогдсон болон Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтнууд болох нийт 13 албан тушаалнуудыг Авлигатай тэмцэх газар болон Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад бүрэн хамруулсан.
		2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага,	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Тус төвөөс 14 аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд дэмжлэгт хяналт хийх үйл ажиллагааны үеэр Авлигаас ангид байх, урьдчилан сэргийлэх, авлига ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл өгсөн. Бэлтгэсэн сургалтын

		үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.		материалыг орон нутгуудад илгээж, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан сургалтын материал бэлтгэн шинээр орж буй эмч, мэргэжилтнүүдэд мэдээллийг тогтмол хүргэж байхыг зөвлөсөн.
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	2023 онд тус төвөөс бусад байгууллагуудтай 84 гэрээ байгуулж ажилласан байна. Батлагдаж буй гэрээнүүдэд Нийтлэг үндэслэл хэсэгт “Монгол Улсын Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх. Тус хуулийн 6 дугаар зүйлд заасан Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх, 7 дугаар зүйлд заасан хориглох зүйлсийг зөрчихгүй байх.” гэсэн заалтыг, Талуудын хариуцлагыг заасан хэсгүүдэд "Талууд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна" гэсэн заалтуудыг оруулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

		3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.	Үйл ажиллагааны өвөрмөц онцлог, био аюулгүй ажиллагаа, био хамгаалал, био халдлагаас сэргийлэх зорилгоор Нууцын тухай хуулийн 13.1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын О.16 дугаар заалт “Эрүүл мэндийн салбарын онц чухал обьектын байршил, олгосон газрын нэр зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл нь олон нийтэд нууц байх”-аар тусгагдаж, 2017 оны 283 дугаар тогтоолын “Дотоодын цэргийн албажиллагааны дүрэм”-ийн дагуу дотоодын цэргийн 05 дугаар ангийн хамгаалалтад зоонозын халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээг зохион байгуулдаг. Иймд Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг тогтмол хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байдаг.
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх;	Тус төв нь үйлчлүүлэгчгүй, лавлагаа шатлалын төв учир авлига, сонирхлын зөрчилд өртөх эрсдэл багатай байдаг. Төвийн хүний нөөцийн болон санхүү, тендэрийн ил тод байдлын ханган байгууллагын албан ёсны веб хуудсанд ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. Ил тод байдлын мэдээллийг нийтэлсэн байдлыг хавсаргав.
		4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	14 аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд сургалт хийх, мэдээлэл хүргэх үеэр Зоонозын салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх ямар эрсдэл байгаа талаар хэлэлцүүлж, хэрхэн урьдчилан сэргийлэх тухай ярилцлага өрнүүлсэн. Зоонозын салбар нь үйлчлүүлэгчгүй, оргүй төв учир авлигын эрсдэл багатай гэж үзсэн бөгөөд хүний нөөцийн болон

				санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласнаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан бүрэн сэргийлж чадах юм гэдэгт санал нэг байлаа.
		4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Хамааралгүй
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Арга хэмжээнд удирдлагын -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс 2023 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрүүл мэндийн яамны төлөвлөгөөтэй уялдуулан баталж, нийт ажилтнуудад мэдээллэсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг эхний хагас жилийн байдлаар гаргаж, ЭМЯ-нд хүргүүлсэн бөгөөд байгууллагын шуурхай хурлаар бүх ажилтан, албан хаагчдад мэдээллэсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт, хийсэн ажил, хүрсэн үр дүнгийн талаар 12 сарын 28-ны өдөр бүх ажилтнуудын хурлаар мэдээлэл хүргэнэ.
		5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Энэ онд Авлигатай тэмцэх газраас дүрэм, журам, ёс зүйн төсөлд санал авахаар төсөл ирүүлээгүй.
		5.3. “Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах”. 5.3.1.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлгүүдийн дотоод зохион байгуулалт, байршлыг иргэдэд ойлгомжтой тэмдэгжүүлэх, эмнэлгүүдийн хүлээн авах, яаралтай тусламж үзүүлэх хэсгийг иргэн үйлчилгээ авахад	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх;	Төвийн гадна талбайд шаардлагатай үед шинжилгээ авах цэгийг үүдний хэсгээс эхлэн байршлыг заасан тэмдэглэгээ хийж байршуулсан.

		чирэгдэлгүй болгох зорилготой аяныг улсын хэмжээнд зохион байгуулах;		
		5.3.2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн үйлчилгээний удирдамж /заавар/ баталж, хэрэгжүүлэх;	-Үйлчилгээний стандарт батлагдсан байх;	Төв нь үйл ажиллагаандаа эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг баримтлан ажиллахаас гадна Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/161 дүгээр тушаалаар батлагдсан Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар, хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн зааврыг үйлчилгээндээ баримтлан, хэрэгжүүлэн ажилладаг.
		5.3.3. Эмнэлгийн байгууллагуудын авто зогсоолын талаарх судалгаа гаргаж, хууль, журамд нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	-Үр дүнг нэгтгэн гаргаж, төлбөртэй авто зогсоолын асуудлыг шийдвэрлэсэн байх;	Тус төв нь лавлагаа шатлалын, үйлчлүүлэгчгүй төв учир төлбөртэй зогсоол байхгүй. Мөн төвд ажилтны болон гадны автомашин нэвтрэн ороход харуул хамгаалалтаар шалгуулан, Ерөнхий захирлын баталсан нэвтрэх зөвшөөрлийн дагуу нэвтрүүлдэг.
		5.3.4.Эмнэлгүүдийн төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, тарифын судалгаа хийх, хуульд нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	- Судалгаа гаргаж, гадагшаа чиглэсэн журам, тариф баталсан шийдвэрүүдийг хүчингүй болгосон байх;	Тус төвөөс хууль журамд нийцүүлэн Ерөнхий захирлын 2023 оны А/11 дүгээр тушаалаар “Төлбөртэй үзүүлэх зоонозын халдварт өвчний лабораторийн шинжилгээ, сайн дурын дархлаалжуулалтын төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ыг батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна.
		5.3.5. АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пейж хуудсыг эмнэлгийн мэргэжилтнүүдээр дагуулах ажлыг зохион байгуулах;	- Аян, хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаанд тус пейжийг сурталчилж, иргэд, төрийн албан хаагчдаар дагуулж, үр дүнг тооцсон байх	АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пейж хуудсыг Зоонозын ажилтнуудын группд сурталчилан 70 гаруй хүн дагасан байна.
		5.3.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлөө шан харамж, бэлэг, албан бус төлбөр авахыг хориглосон зохицуулалтыг сурталчилсан агуулгатай контент бүтээж, түгээх;	- Контентыг олон нийтэд түгээсэн байх;	Тус төвийн эмч, мэргэжилтнүүдийн төлөөллийг оролцуулан “Авлигын эсрэг нэгдэе-Үгүй гэж хэлээд өөрчилье” сэдэвт 1 минут 30 секундын контент хийж, төвийн веб болон цахим хуудсанд байршуулан, авлигын эрсдэлээс ангид байх, урьдчилан сэргийлэх сурталчилгааг олон нийтэд түгээсэн. Нийт хандалт 3614 байна.

				Холбоос: https://www.facebook.com/nczd.gov/videos/862832731892069/
		5.3.7. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, эмнэлгийн ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг шуурхай, үнэн зөв шийдвэрлэх, иргэнд заавал хариу мэдэгдэх, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах;	-Тайлагнасан байх	Энэ онд тус төвд гадны иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол байхгүй.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ